

БАЯНГОВЬ СУМЫН ТАМГЫН ГАЗАР, ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН  
ХОРООНЫ 2025-2028 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ХАМТЫН ГЭРЭЭ

2025 оны 01 дүгээр сарын 31

Өргөн

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү гэрээг Монгол улсын Нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенц, Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг үндэслэн нэг талаас Баянхонгор аймгийн Баянговь сумын Засаг даргын тамгын газрын захиргаа./ цаашид ажил олгогч гэх / нөгөө талаас нийт ажилчдыг төлөөлж Баянхонгор аймгийн Баянговь сумын Засаг даргын тамгын газрын ажилтнуудын ҮЭ-ийн хороо./ цаашид ажилтны төлөөлөгч, хамтад нь талууд гэх / харилцан тохиролцож байгуулав.

1.2.Хамтын гэрээ нь гурван жилийн хугацаанд үйлчилнэ./хтх-31.3/

1. 3.Хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал

хариуцсан төрийн байгууллагад бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно. /хтх-32.2/

1.4 Энэхүү гэрээний 1.3-т заасан гэрээний хугацаа дуусахад шинээр гэрээ байгуулаагүй,нэмэлт өөрчлөлт оруулаагүй бол нэг удаа анх байгуулсан хугацаанаас илүүгүй хугацаагаар сунгагдсанаар тооцно./хтх-31.5/

1.5.Энэхүү гэрээний цалин хөлстэй холбоотой зохицуулалтыг нэг жилээс доошгүй хугацаа

өнгөрсний дараа дахин хэлэлцээ эхлүүлэхээр санаачлах эрхтэй. /хтх-31.4/

1.6.Байгууллагын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн нөхцөлд хамтын гэрээ мөн хүчин төгөлдөр мөрдөгдөнө./хтх-40.1/

1.7.Талууд хамтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа нөгөө талд энэхүү

гэрээний хугацаа дуусгавар болохоос 10 сараас доошгүй хугацааны өмнө гарган бичгээр хүргүүлж байна. /хтх-20.4/

1.8.Талууд гэрээнд заасан аливаа асуудалд тэгш эрхтэй оролцох бөгөөд энэхүү хамтын гэрээ хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль тогтоомжид бүрэн нийцсэн байх, хууль тогтоомжоор ажилтанд олгосон эрхийн баталгаат түвшин, суурь хэм хэмжээг бууруулаагүй байх, харилцан тохиролцох замаар ажилтны хувьд сайжруулсан байх зарчмыг баримтална. /хтх-12.2.1/

1.9.Энэхүү хамтын гэрээнд талууд хяналт тавих бөгөөд МҮЭ-ийн гишүүдийг хамаарч үйлчилнэ. \хтх39.2 \

1.10.Хамтын гэрээний бүрэн эхийг 3 хувь үйлдэж хамтын гэрээнд оролцогч талууд

хадгална.

## **ХОЁР. ЦАЛИН, ХӨЛС**

2.1. Байгууллагад мөрдөгдөх ажилчдын үндсэн цалингийн сүлжээг ажил албан тушаал бүрээр гаргаж үндсэн цалингийн сүлжээг Хөдөлмөр нийгмийн түншлэлийн 2 болон 3 талт хэлэлцээрийн дагуу нэмэгдүүлнэ.

2.2 Ажил олгогч нь ажилтнуудын цалин хөлсийг бодит инфляцын түвшин, ажлын ачаалалтай уялдуулан, Засгийн газраас төрийн албан хаагчийн цалин хөлсийг нэмэгдүүлэх тохиолдол тус бүрд нэмэгдүүлсэн хувиар нэмэгдүүлнэ.

2.3 Ажил олгогч нь хөдөлмөрийн дотоод журам албан тушаалын жагсаалт, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн норм, норматив үндсэн цалингийн сүлжээ, жишиг болон нэмэгдэл хөлс, нэмэгдлийн хэмжээ, шагнал урамшуулал, түүнийг олгох журмыг ҮЭ-ийн хороотой зөвшилцөж баталж мөрдүүлнэ./хтх-106.1/

2.4 Ажилтан үндсэн ажлынхаа зэрэгцээ ажил албан тушаал хавсран ажилласан бол 40 хувиар, мэргэжил хослон ажилласан бол 40 хувиар, эзгүй ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн бол 40 хувиар, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн бол 20 хувиар тухайн ажилтны үндсэн тарифт цалингаас нь тус тус тооцон нэмэгдэл хөлс олгоно. Ээлжийн амралттай байгаа хүнийг орлон ажиллаж байгаа тохиолдолд нэгэн адил нэмэгдэл хөлсийг олгоно./хтх-109.6/

2.5 Ажил олгогчийн шаардлагаар илүү цагаар ажилласан бол ажилласан долоо хоногийн аль нэг тохиромжтой ажлын цагт нөхөж амраах, нөхөж амраагүй тохиолдолд илүү цагийн хөлсийг 1.5 дахин нэмэгдүүлэн тухайн сарын цалин дээр нь олгох. /хтх-109.2/

2.6 Шөнийн цагаар ажилласан ажилтанд шөнө ажилласан цаг тутам 1.5 хувиар нэмэгдүүлэн тооцож нэмэгдэл олгоно./хтх-109.3/

2.7. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд дор дурдсан хөнгөлөлт үзүүлнэ. Үүнд:

1. Дундаж цалин хөлсний 20 хувьтай тэнцэх нэмэгдэл сар бүр олгоно.
2. Ажлын тусгай хувцас хэрэгслээр хангаж, угааж цэвэрлэх, ариутгах бодис олгоно.
3. Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүнд өдөрт 1000 гр цэвэр сүүг тухайн үеийн зах зээлийн ханшаар нь тооцож бодож цалин дээр нь нэмж олгоно./хтх-120.3/

2.8. Ажилтныг 7 хоног бүрийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажиллуулаад нөхөн амруулаагүй бол үндсэн тарифт цалинг 1.5 дахин нэмэгдүүлж олгоно. /ээлжээр ажилладаг ажилтанд нэгэн адил хамаарна/ /хтх-109.9/

2.9 Ажилтанд дараах нэмэгдлүүдийг олгоно. /тодорхой хувь хэмжээ, тоо заавал нэг бүрчлэн заах/

1. Тасралтгүй ажилласан жилийн нэмэгдэл
2. Мэргэжлийн зэргийн нэмэгдэл
3. Ур чадварын нэмэгдэл
4. Хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл

### 5..Бусад нэмэгдэл /хтх-109.6/

2.10 Ажилчдын ажлын чанар, үр дүнтэй шууд холбож дараах шагналуудыг доорх хувь хэмжээгээр бодож олгоно.Үүнд:

А. Сарын ажлын үр дүнгийн гүйцэтгэлээс хамаарч урамшуулал үндсэн цалингийн 40 хувиар,

Б. Жилийн эцсийн үр дүнгийн урамшуулалт 13 дахь сарын цалин 1 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэхүйц хэмжээгээр олгох бөгөөд энэхүү урамшууллыг сахилгын шийтгэл ногдуулсан ажилтанд олгохгүй.

### С. /хтх-109.6/

2.11.Хөдөлмөрийн хөлс олгохтой холбогдсон дүрэм журам, тэдгээрт оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр нийт ажилтанд ажил олгогч мэдээлэх үүрэгтэй.

2.12.Цалин хөлсийг сард 2 удаа хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заасан хугацаанд олгох бөгөөд бүх нийтээр амрах болон баярын өдөр таарсан бол ажлын өмнөх өдөр нь олгох бөгөөд цалин хөлсийг хугацаанд нь олгоогүй тохиолдолд хоног тутамд 0,5 хувийн алданги тооцож нэмэгдүүлэн олгоно. /хтх-124.1/

2.13.Ажил олгогчоос үл шалтгаалан гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан аюулт үзэгдэл, эрх бүхий төрийн байгууллагын шийдвэрийн улмаас, эсхүл ажилтнаас үл шалтгаалах сул зогсолтын хугацаанд түүнийг өөр ажилд шилжүүлэх боломжгүй бол түүнд үндсэн цалингийнх нь 70-аас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний олговор олгох бөгөөд олговрын хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доогуур байж болохгүй. /хтх-116,1/

2.14.Эцэгт шинээр төрсөн хүүхдээ асрахад нь зориулан ажлын 10 өдрийн чөлөөг ажил олгогч олгож, тухайн хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговор олгоно. /хтх-137.5/

2.15.Хөдөлмөрийн нормоо биелүүлээгүй нь ажилтны буруугаас шалтгаалаагүй бол гүйцэтгэсэн ажилд нь ногдох цалин хөлснөөс гадна үндсэн цалингийн зөрүүтэй тэнцэх хэмжээний олговор олгоно. /хтх-114.1/

2.16.Ажил олгогч ажилтны хүсэлтээр 1 сарын цалингийн урьдчилгаа олгож болно. /хтх-104.5/

2.17.Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Мартын 8-ны баярыг тохиолдуулан эмэгтэй ажилтнуудад байгууллагын захиргаа нь 50,000 төгрөгийн гарын бэлэг гардуулна. ҮЭ-ийн хорооноос эмэгтэйчүүдийн хөдөлмөрлөх эрхийг хамгаалах талаар тодорхой ажил зохионо. Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан эмэгтэйчүүдийг шагнаж урамшуулна.

2.18.Байгууллагын шагналаар шагнуулсан тохиолдолд ажилтанд 150,000 төгрөг өгөх.

2.19.Төрийн одон медалиар шагнуулсан ажилтанд байгууллагын захиргаанаас 150,000 төгрөг, ҮЭ-ийн хорооноос 100,000 төгрөгийн гарын бэлэг тус тус гардуулна. /хтх-101/



2.20.Байгууллага хамт олныг жилд нэг удаа идэвхтэй амралт, эрүүл мэндийн үзлэг оношилгоо шинжилгээ, эрт илрүүлэг, аялал, сургалтад зориулж зохион байгуулахад байгууллагаас 1,000,000 төгрөг, ҮЭ-ээс 2,000,000 хүртэлх төгрөг тус тус олгоно.

2.21.Цалингийн зардлаас ажилтан албан хаагчдад хоолны мөнгийг ажлын өдрөөр тооцож 1 өдрийг 10,000 - 15,000 төгрөгөөр бодож үндсэн цалин дээр нэмж олгоно.

### **ГУРАВ. ТЭТГЭВЭР,ТЭТГЭМЖ, ТУСЛАМЖ, ХӨНГӨЛӨЛТ /хтх-37.1.3/**

3.1. Аж ахуй нэгж байгууллага болон түүний салбар нэгж татан буугдсан, ажлын байр хасагдсан, ажилтны тоог цөөрүүлсэн, ажилтан мэргэжил, мэргэшлийн түвшин, ур чадвар, ажлын гүйцэтгэлийн болон эрүүл мэндийн хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон, өндөр насны тэтгэврээ тогтоолгосон ажилтанд нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмж авах эрхтэй эсэхээс үл хамааран уг ..... салбарт ажилласан жилээр тооцон олгоно. Мөн ажилтныг бөөнөөр халах үед дор дурдсан тэтгэмжийг ажилтанд олгоно. Үүнд: /82/

3.1.1.6 сараас 2 жил хүртэл ажилласан бол 2 сарын

3.1.2.2 жилээс 5 жил хүртэл ажилласан бол 3 сарын

3.1.2.3 5 жилээс 10 жил хүртэл ажилласан бол 4 сарын

3.1.2.4 10 жилээс 12 жил хүртэл ажилласан бол 6 сарын

3.1.2.5 13 жилээс 19 жил хүртэл ажилласан бол 10 сарын

3.1.2.6 20 жилээс 25 жил хүртэл ажилласан бол 25 сарын

3.1.2.7 25-аас дээш жил хүртэл ажилласан бол 36 сарын дундаж цалин, хөлстэй тэнцэх тэтгэмж нэг удаа олгоно. /хтх-82/

3.2.Захиргаа ажлын байранд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ ... сарын өмнө ҮЭ-ийн хороонд урьдчилан мэдэгдэж, саналыг нь аван ажилтны хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах боломжоор ханган нийгмийн хамгааллын асуудлаар хэлэлцээг хийж тэтгэмжийг асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

3.3.Захиргаа нь ажлын байранд бүтэц зохион байгуулалт хийдээ өрх толгойлсон, байнгын асаргаа шаардлагатай хүүхэдтэй, тэтгэвэр гарахад нэг жил дутуу байгаа ажилтнуудыг харгалзан үзэж бүтэц зохион байгуулалтад хамруулахгүй байх бодлого баримтална .

3.4.Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтанд хүүхдийн эмчилгээний зардалд зориулж гаргасан хүсэлт болон эмнэлгийн магадалгааг үндэслэн байгууллагын захиргаанаас жилд 1 удаа 150,000 төгрөгийн тэтгэмж үзүүлнэ.

3.5.Ажилтан шинээр гэр бүл болсон тохиолдолд холбогдох баримт бичгийг үндэслэн 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 200,000 төгрөгийн дэмжлэг нэг удаа олгоно.

3.6.Байгууллагын захиргаанаас ажилтанд хүүхэд төрүүлж, хүүхэд асрахад нь зориулж өөрийнх нь хүсэлтийг үндэслэн нэг удаа 150,000 төгрөгийн тэтгэмж олгоно. Энэ

тэтгэмж нь нярай хүүхэдтэй ганц бие эцэг, хүүхэд үрчлэн авсан ажилтанд нэгэн адил хамаарна.

3.7. Ажилтнуудын ажлын мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх зорилгоор ажилтан их, дээд сургууль, коллеж болон мэргэжил дээшлүүлэх курст 3 сараас дээш суралцах тохиолдолд ажилтныг суралцах хугацаанд нь хичээлийн цагаар ажлаас чөлөөлж, үндсэн цалин хөлсийг олгож, ажлын байрыг нь хэвээр хадгална. Энэ тохиолдолд төлбөрөөс нь 40 хувиар дэмжлэг үзүүлнэ.

3.8. Хүндээр өвдсөн, Улаанбаатар болон бусад хотуудад эмчилгээ хийлгэхээр болсон ажилтанд ҮЭ-ийн хорооны тэргүүлэгчдийн шийдвэрээр нэг удаа буцалтгүй тусламж үзүүлнэ.

3.9. Ажилтан нас барсан тохиолдолд, ажил олгогч автомашинаар үйлчилж, ар гэрт нь 500,000 төгрөгийн мөнгөн тусламж олгоно.

3.10. Ажилтны гэр бүлийн гишүүн/ нөхөр, эхнэр, төрсөн эцэг, эх, хадам эцэг, эх, үр хүүхэд/ нас барвал ажил олгогч автомашинаар үйлчилж, 200,000 төгрөгийн мөнгөн тусламж олгоно.

3.11. Өндөр насны тэтгэвэрт гарч буй ажилтанд тэтгэмж, 1 сарын үндсэн цалинг, бэлэг дурсгалын зүйлийг ажил олгогч нэг удаа олгоно.

3.12. Ажилтан асрамжид байгаа хүмүүсээ /эхнэр, нөхөр, төрсөн эцэг, эх, хүүхдүүд/ хүнд өвчтэй үед нь сахисан тохиолдолд эмчийн магадалгааг үндэслэн 1 сар хүртэл цалинтай чөлөө олгож болно.

3.13. Ажилтны гэр орон байгалийн аливаа гамшиг гэнэтийн аюулд нэрвэгдсэн бол байгууллагаас нэг удаа 500,000 төгрөг, ҮЭ-ийн хорооноос 300,000 төгрөг тус тус олгоно.

3.14. Улс, аймгийн чанартай тэмцээнд амжилт гаргасан бол байгууллагаас нэг удаа 150,000 төгрөг, ҮЭ-ийн хорооноос 100,000 төгрөг тус тус олгоно.

3.15. Тухайн байгууллагад ажиллаж байсан өндөр настнуудад ахмадын баяраар жилд нэг удаа хүндэтгэл үзүүлнэ.

3.16. Олон улсын хүүхдийн баяраар байгууллагын албан хаагчдын 0-16 насны хүүхдүүдэд баярын бэлгийн 50%-ийг байгууллагаа өгнө.

3.17. Албан хаагчдын ажлын дүрэмт хувцсаар хангах ҮЭ-ийн хорооноос хувцасны үнийн дүнгийн 50% хүртэлх, 50% -ийн албан хаагч хариуцна.


3.18. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа:

А.30 хүртэл хувиар алдсан ажилтанд ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 5 дахин

Б.30-50 хувиар алдсан ажилтанд ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 7 дахин

В.50-70 хувиар алдсан ажилтанд ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 9 дахин

Г.70 ба түүнээс дээш хувиар алдсан ажилтанд ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 18 дахин



Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас нас барсан нь эмнэлгийн байгууллагын шинжилгээ, магадалгаагаар тогтоогдсон ажилтны ар гэрт ажилтны нэг сарын дундаж цалин хөлсийг 36 дахин нэмэгдүүлсэн нөхөн төлбөрийг нэг удаа олгоно. /хтх-125,2/

3.19. Амьжиргааны өртгийн өөрчлөлттэй уялдуулан энэхүү гэрээний 3.18,3.19 -д заасан нөхөн төлбөрийн хэмжээг индексжүүлэх, хөдөлмөрийн чадвар алдалтын хувьд нэмж өөрчлөлт ороход нэмэгдүүлэн олгоно. /хтх-125.4/

#### **ДӨРӨВ. АЖИЛ АМРАЛТЫН ЦАГ**

4.1. Ажил олгогч нь ҮЭ-ийн хорооны саналыг харгалзан ажлын цагийн уян хатан цагийг тогтоон мөрдүүлж болно. /хтх-37.1.4/

4.2. Илүү цагаар болон 7 хоногийн амралт, баяр ёслолын өдрүүдэд ажиллагсдыг ажиллуулахдаа ҮЭ-ийн хороонд мэдэгдэж байна.

4.3. Ажил олгогч нь ажиллагсдад доор дурдсан шалтгаан хугацаагаар цалинтай чөлөө олгоно.

1. Ажилтан хурим хийвэл ажлын 7 өдөр

2. Хүүхэд нь хурим хийвэл ажлын 5 өдөр

3. Эцэг эх, хадам эцэг эх, төрсөн ах дүү болон гэр бүлийн хүмүүс нас барвал ажлын 5 өдөр

4. Эцэг эх гэр бүлийн хүмүүс өвчилсний улмаас тэднийг асрамжилсан бол ажлын 10 өдөр

5. Дээд шатны эмнэлэгт үзлэг шинжилгээ хийлгэхэд ажлын 10 өдөр

6. Бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилтанд ажлын 5 хоногийн чөлөө сард 1-2 удаа олгож болно.

4.4. Хөдөлмөрийн хэвийн нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дараах нэмэгдэл амралт олгоно.

1. 6 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 3 өдөр;

2. 11 дахь жилийн эхнээс 15 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 5 өдөр;

3. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 7 өдөр;

4. 21 дахь жилийн эхнээс 25 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 9 өдөр;

5. 26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуусталх хугацаанд ажлын 11 өдөр;

6. Дахь жилээс ажлын 14 өдөр. /хтх-99.5/

4.5.32 Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дараах нэмэгдэл амралтыг олгоно.

А. 6 дахь жилийн эхнээс 10 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 5 өдөр;

Б. 11 дэх жилийн эхнээс 15 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 7 өдөр;

С. 16 дахь жилийн эхнээс 20 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 9 өдөр;



D.21 дэх жилийн эхнээс 25 дахь жилийг дуусталх хугацаанд ажлын 12 өдөр;

E.26 дахь жилийн эхнээс 31 дэх жилийг дуусталх хугацаанд ажлын 15 өдөр;

F. өдөр./хтх-99.6/

4.6. Ажилтны ажлын цагийг доор дурдсан хэмжээгээр богиносгоно.

A.Мэргэжил эзэмшүүлэх дээшлүүлэх сургалтад хамрагдсан ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь цагаар

B.0-2 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэй ажилчдын /мөн ганц бие эцэг/ ажлын цагийг 1 жилийн хугацаанд .....цагаар

C. Бусад /хтх-85/

4.7.Ажил үүргийн онцлогоос шалтгаалан завсарлах боломжгүй ажилтныг ажил олгогч хооллох бололцоогоор хангах бөгөөд ажлын цагаас хасаж тооцохгүй. Үүнд хамрагдах ажил үүргийн жагсаалтыг хавсралтаар батална.

## **ТАВ. ХӨДӨЛМӨР ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦЛИЙГ САЙЖРУУЛАХ**

5.1.Ажил олгогч хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заасны дагуу үйл ажиллагааны зардлын 1,5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг ХАБЭА-н болон ҮОХХМШӨ-нөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулж байна.

5.2.Ажил олгогч нь нийт ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагад хийлгэнэ.

5.3 Ажил олгогч нь хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилтанд дараах хөнгөлөлт эдлүүлнэ.

1. Ажлын өдрийг богиносгох
2. Үндсэн хөлсөн дээр нь сар бүр нэмэгдэл олгох
3. Бусад

5.4.Ажил олгогч нь ажилтныг хөдөлмөрийн нөхцөл ажил үүргийн онцлогт тохируулан аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэглэлээр хангах бөгөөд тэдгээрийг ариутгаж засварлана.


5.5.Ажил олгогч хөдөлмөр хамгааллын кабинет байгуулж нийт ажилтнуудыг холбогдох мэдээлэл заавраар хангах төлөвлөөг хэрэгжүүлнэ.

## **ЗУРГАА. ҮЭ-ИЙН ЭРХИЙГ ХАНГАХ ТУХАЙ**

6.1 Байгууллагын захиргаа ҮЭ-ийн хорооны үйл ажиллагаа явуулах боломжоор ханган өрөө тасалгаа гаргаж өгөх, техник хэрэгслээр бүрэн хангах үүрэгтэй.

6.2. ҮЭ-ийн сонгуультнуудыг нийгмийн асуудлыг шийдвэрлэх, урамшуулалт цалин хөлс олгох, аливаа арга хэмжээнд нийт ажилтнуудын нэгэн адил хамруулна.

6.3. Байгууллагын захиргаа нь гишүүдийн татварыг МҮЭ-ийн Холбооны дүрмийн 14.1. "Үйлдвэрчний эвлэлийн хороод нь гишүүдийнхээ татварыг сарын цалин хөлс, түүнтэй



адилтгах орлогын нэг ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээгээр тогтоож, сар бүр бэлэн бусаар хураана". гэсэн заалтыг үндэслэн бэлэн бусаар цалин тавьснаас хойш ажлын 5 хоногийн дотор сумын ҮЭ-ийн холбооны дансанд шилжүүлнэ.

6.4. Байгууллага дээр гарсан хөдөлмөрийн хамтын маргааныг МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

6.5. Үндсэн ажлаасаа чөлөөлөгдөөгүй ҮЭ-ийн сонгуультан болон ҮЭ-ийн гишүүдийг Олон улсын, салбарын, орон нутгийн болон ҮЭ-ийн хурал зөвлөгөөн, сургалт, семинар, дамжаа, туршлага солилцох хурал болон бусад үйл ажиллагаанд оролцох тохиолдолд цалинтай чөлөө олгож оролцуулах арга хэмжээг авна.

6.6. Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон дотоод журам, ажилтнуудын эрх ашигтай холбогдох асуудлаар аливаа шийдвэр гаргахдаа ҮЭ-ийн хороо болон салбарын ҮЭ-ийн холбоонд ажлын 15 хоногийн өмнө урьдчилан мэдэгдэж санал авсны үндсэн дээр шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах эрх бүхий хурал, зөвлөгөөнд ҮЭ-ийн төлөөллийг оролцуулна.

## **ДОЛОО. ХАМТЫН ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ,НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ**

7.1. Энэхүү хамтын гэрээ нь бүртгүүлсэн өдрөөс эхлэн 2025-2028 он дуустал мөрдөгдөнө.

7.2. Хамтын гэрээний биелэлтийг ажил олгогч, ҮЭ-ийн хороо улирал тутам гаргаж нийт ажиллагсдад мэдээлнэ.

7.3. Хоёр тал өөрт байгаа гэрээний хэрэгжилттэй холбоотой бүх мэдээллийг тогтмол солилцох үүрэг хүлээнэ.

### **НАЙМ. БУСАД ҮНДЭСЛЭЛ**

8.1. Баянговь сумын Засаг даргын тамгын газар, ҮЭ-ийн хорооны 2025-2028 оны энэхүү хамтын гэрээ нь талууд гарын үсэг зурж, сумын ҮЭ-ийн холбооны мөн байгууллагын тамга, тэмдэг дарж, харьяа нутаг дэвсгэрийн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагад бүртгүүлэн, баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд дараагийн хамтын гэрээ хүчин төгөлдөр болтол хэвээр мөрдөнө


8.2.Хамтын хэлэлцээр хийхтэй холбогдсон зардал болон талууд урьдчилан тохиролцож урьж оролцуулсан мэргэжилтэнд олгох хөлс бусад зардлыг тооцох журмыг талууд хамтран баталж мөрдөнө.

8.3.Хамтын гэрээгээр тохиролцсон асуудлыг биелүүлж байгаа нөхцөлд ажил хаялт зохион байгуулахгүй байх асуудлыг ҮЭ-ийн хороо хүлээнэ.

8.4.Энэхүү гэрээний хавсралт болон доор дурдсан баримт бичгийг ажил олгогч ҮЭ-ийн хороотой зөвшилцөн баталж мөрдүүлнэ.

А. Ажилтныг ажилд авах, ажлаас халах журам

Б. Сахилгын шийтгэл ноогдуулах журам





В. Хөдөлмөрийн дотоод журам

Г. Ажил албан тушаалын жагсаалт

Д. Ажлын байрны тодорхойлолт болон албан тушаалын лавлах

Е. Хөдөлмөрийн норм, норматив

Л.Бусад



# ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЖИЛ ОЛГОГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

БАЯНГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ

Б.МӨНХ-ОЮУН

Б.НАРАНБАЯР

И.БУДЬСҮРЭН

ҮЭ-ИЙН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ

БАЯНГОВЬ СУМЫН ҮЭХ-НЫ

ДАРГА Ц.МӨНХТУЛГА

Э.ЦОЛМОНЗАЯА

Д.БАТЖАРГАЛ

Б.ГАНТУЛГА